

Нэгдсэн Үндэстний Байгууллага



Хөгжлийн бэрхшээлтэй
хүний эрхийн хороо

ТЭГШ БАЙДАЛ БОЛОН ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАХГҮЙ БАЙХ ТУХАЙ

ЕРӨНХИЙ ТАЙЛБАР-6

Улаанбаатар хот
2025 он



Орчуулгын санаачлагч:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй
эцэг эхчүүдийн холбоо

Монгол хэлэнд хөрвүүлсэн:

ХБХЭЭХолбооны зөвлөх Э.Цолмон

Орчуулга, хэвлэлийг санхүүжүүлэгч:

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй
3P4D ОРОЛЦОО тэтгэлэгт хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй
хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны

"Хамтын оролцоотой Хүртээмжтэй орон нутаг" төсөл.
400 хувь хэвлэв.

**FUNDING
WINDOWS**





ӨМНӨХ ҮГ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчид алхам тутамдаа эрхээ эдэлдэг байх, нийгмийн бүх харилцаанд бүрэн дүүрэн оролцоотой болгох эрхийн баталгаа бол НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц билээ. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос найман Ерөнхий Тайлбарыг гаргасан байдаг.

НҮБ-ын Хүүхдийн сан анх "Тэгш хамран сургах эрхийн тухай" Ерөнхий тайлбар 4 (2014)-ийг орчуулан нийтэд түгээсэн. Манай холбоо 2024 онд Ерөнхий тайлбар-2 (2016)-ыг орчуулж, хэвлэн мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Энэ удаад "Тэгш байдал болон ялгаварлан гадуурхахгүй байх тухай" Ерөнхий тайлбар №6, "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор хүүхдүүд, өөрсдийн төлөөллийн байгууллагаар дамжуулан конвенцийн хэрэгжилт ба хяналтад оролцох тухай" Ерөнхий тайлбар №7-г Монголд анх удаа ХБХЭЭХолбоо орчуулж бэлэн болгов.

Орчуулга, найруулгатай холбоотой саналыг нээлттэй хүлээн авч, цаашид засан сайжруулах тул Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны info.apdcmongolia@gmail.com хаягаар бидэнтэй холбогдохыг хүсье. www.apdc.mn сайтад цахим хувилбар байршив.

Хүн бүрийн баяр жаргалтай амьдралын төлөө хамтдаа!

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй
эцэг эхчүүдийн холбоо

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ



5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл ялгаварлах

1. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд хуулиар ямарваа нэгэн ялгаварлалгүйгээр тэгш хамгаалуулж, адил ашиг хүртэх эрхтэй болохыг оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.
2. Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр ялгаварлах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн ялгаварлалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно.
3. Тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, ялгаварлалыг устгах үүднээс оролцогч улсууд нь боломжит зохицлыг хангах бүхий л алхмыг хийнэ.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлыг de facto хангах, ийм байдлыг бий болгоход чиглэсэн зайлшгүй шаардлагатай тусгай арга хэмжээнүүдийг энэхүү конвенцийн агуулгад ялгаварлал гэж үзэхгүй.





Хөгжлийн бэрхшээлтэй
хүмүүсийн эрхийн тухай
конвенц

Түгээлт: Ерөнхий
2018 оны Дөрөвдүгээр сарын 26
Эх хувь: Англи

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ХОРОО

ТЭГШ БАЙДАЛ БОЛОН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГҮЙ БАЙХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ТАЙЛБАР №6** (2018)

I. ОРШИЛ



1. Энэхүү Ерөнхий тайлбарын зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн 5 дугаар зүйлд заасан **ялгаварлан гадуурхахгүй байх болон тэгш байдлын зарчимтай холбоотойгоор Гишүүн улсуудын хүлээх үүргийг тодорхой болгох явдал юм.**
2. Хороо Гишүүн улсуудын хууль, бодлого нь хөгжлийн бэрхшээлийг **буяны эсвэл анагаахын загвараар** авч үзсээр байгаа нь уг конвенцийн үзэл баримтлалтай үл нийцэж байна хэмээн үзэж байна. Ийм үзэл баримтлалын тогтвортой хэрэглээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг **эрх агуулагч субъект** хэмээн бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөхөд саад болж байна. Үүнээс гадна Гишүүн улсуудын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх **хандлагын саадыг арилгах хүчин чармайлт хангалтгүй** хэвээр байна. Жишээлбэл: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг "нийгмийн ачаа" гэж үзэх хэвшмэл ойлголт, гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт өнөөг хүртэл түгээмэл байна. Ийм нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн төлөөллийн байгууллагуудаар дамжин хууль, бодлогын шинэчлэлийн үйл явцад голлох байр суурь эзлэх нь нэн чухал юм.
3. Ялгаварлан гадуурхахын эсрэг хууль, хүний эрхийн тогтолцоог өргөжүүлснээр олон улсын болон үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах хүрээ өргөжсөн. Гэсэн хэдий ч хууль, зохицуулалтын орчин нь ихэвчлэн **цогц бус, бүрэн бус эсвэл үр нөлөө султай** хэвээр байна. Мөн хөгжлийн бэрхшээлийн хүний эрхийн загварыг хангалттай ойлгоогүйгээс ялгаварлан

* 2018 оны 5 дугаар сарын 18-нд техникийн шалтгааны улмаас дахин нийтлэв.

** 2018 оны 2 дугаар сарын 14-нөөс 3 дугаар сарын 9-ний хооронд болсон Хорооны XIX (19 дүгээр) чуулганаар батлав.

гадуурхалт, тусгаарлалт, хүчирхийллийг хэвээр хадгалж байна. Тухайлбал, олон улсын болон үндэсний хууль, бодлого нь дараах нийтлэг сул талыг агуулж байна:

- **Олон давхар** (Multiple discrimination), **хамааруулан ялгаварлах** (Discrimination by association) **болон огтлолцсон** (Intersectional discrimination) **ялгаварлан гадуурхалтыг** үл тоомсорлох;
- **Шаардлагатай тохируулгаас татгалзахыг ялгаварлан гадуурхалт** гэж хүлээн зөвшөөрөхгүй байх;
- Үр нөлөөтэй эрх зүйн хамгаалал, нөхөн төлбөрийн механизм дутмаг байх. Ийм төрлийн хууль, бодлого нь ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний ашиг сонирхлыг хамгаалах эсвэл "тэдний эрх ашигт нийцнэ" гэсэн тайлбараар зөвтгөгддөг тул ялгаварлан гадуурхалтын **бодит шинж чанарыг үгүйсгэдэг**.

II. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТЭГШ ЭРХ, ҮЛ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ



4. **Тэгш байдал ба ялгаварлан гадуурхахгүй байх** нь хүний эрхийн олон улсын эрх зүйн хамгийн суурь зарчим, эрхүүдийн нэг бөгөөд хүний эрхэм чанартай салшгүй холбоотой. Энэ нь бүх хүний эрхийн тулгуур суурь бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1, 2 дугаар зүйлд хүн бүр Эрхэм чанар, эрхийн хувьд адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр эрхээ эдэлнэ гэж тунхагласан байдаг.
5. Тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх нь бүх хүний эрхийн гэрээний **үндсэн агуулга** байдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт зэрэгт өргөн хүрээний үндэслэлээр¹ ялгаварлан гадуурхахыг хориглодог. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 5 дугаар зүйлийн эх сурвалж болсон. НҮБ-ын бүх сэдэвчилсэн гэрээнүүдийн зорилго нь ялгаварлан гадуурхлыг арилгаж, тэгш байдлыг тогтоох бөгөөд бүгдэд нь тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх тухай заалт туссан байдаг. Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь эдгээрийн туршлагыг нэгтгэн авч, илүү **шинэ шатны хөгжил** болгон гаргасан.

¹ Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц; Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц; Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг доромжилсон харьцаа, шийтгэлийг эсэргүүцэх тухай конвенц; Хүүхдийн эрхийн тухай конвенц; Цагаач ажилчдын болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц; Албадан алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц.

6. **"Эрхэм чанар"** хэмээх нэр томьёо нь Конвенцод бусад НҮБ-ын хүний эрхийн гэрээнүүдээс илүү олон удаа дурдагддаг. Конвенцын оршил хэсэгт НҮБ-ын Дүрмийн суурь зарчмуудыг сануулж, хүн бүрийн төрөлх нэр төр, үнэ цэнэ, эрхийн тэгш, салшгүй шинж нь дэлхий дахинд эрх чөлөө, шударга ёс, энхийн суурь үндэс гэж онцолсон байдаг.
7. Конвенцын бүхэлд нь **"бусдын адил тэгш үндсэн дээр"** гэх өгүүлбэр давтагдан орсон нь бүх эрхийн хэрэгжилт ялгаварлан гадуурхахгүй байх зарчимтай нягт уялдаж байгааг нотолдог. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхэм чанар, бүрэн бүтэн байдал, тэгш эрх нь олон тохиолдолд ноцтойгоор зөрчигдөж ирсэн бөгөөд өнөөдөр ч үргэлжилсээр байна.

Үүнд:

- Хүний зөвшөөрөлгүйгээр эсвэл хүчээр хийгдсэн ариун цэврийн болон нөхөн үржихүйн мэс ажилбар (албадан үргүйдүүлэх),
- Албадан эмчилгээ болон дааврын тарилга,
- Лоботомид болон "Ashley treatment" гэх мэт туршилтын арга,
- Хүчээр цахилгаан эмчилгээ хийх,
- Албадан тусгаарлалт,
- "Эвтанази" нэрээр системтэй аллага үйлдэх,
- Хүчээр үр хөндөх,
- Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах,
- Биеийн эрхтнийг огтлох, худалдах, ялангуяа альбинизмтой хүмүүсийн эрхтэн наймаалах зэрэг харгис хэлбэрийн зөрчлүүд багтана.

III. НЭГДМЭЛ ТЭГШ БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ЗАГВАР



8. **Хувь хүн төвтэй болон анагаахын загварууд** нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд тэгш байдлын зарчмыг хэрэглэх боломжийг хааж ирсэн. Анагаахын загвараар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх эзэмшигч гэж биш, харин зөвхөн "эмгэг"-ийн түвшинд авч үздэг. Энэ нь ялгаварлан гадуурхах, ялгаатай харьцах, нийгмээс тусгаарлах үзэгдлийг хэвийн мэт ойлгуулж, **"эмнэлгийн үнэлгээнд суурилсан, чадваргүй"** гэх хандлагыг хуульчлан зөвтгөдөг. Түүхийн эхэн үед хөгжлийн бэрхшээлтэй холбоотой олон улсын хууль, бодлого ч энэ загвараар тодорхойлогдож байв.

Жишээлбэл, **Оюуны бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал (1971) болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал (1975)** зэрэг анхны зөөлөн эрх зүйн баримт бичгүүдэд тэгш байдал, ялгаварлан

гадуурхахгүй байх үзэл орсон ч эдгээр нь эмгэгийг эрхийг хязгаарлах үндэслэл гэж үзсэн хэвээр байв. Түүнчлэн эдгээр баримт бичигт одоо бол хоцрогдсон, зохимжгүй гэж тооцогдох хэллэгүүд ашиглагдсан байдаг.

Харин 1993 онд батлагдсан **"Хөгжлийн бэрхшээлтэй хүний боломжийг тэгшитгэх стандарт журам"** нь хөгжлийн бэрхшээлийн бодлого, хууль тогтоомжийн үндсэн ойлголт нь тэгш боломж байх ёстой гэж тунхагласнаараа нэг алхам урагшилсан.

9. Харин **хүний эрхийн загвар** нь хөгжлийн бэрхшээлийг нийгмийн бүтэц гэж хүлээн зөвшөөрдөг бөгөөд эмгэг нь хүний эрхийг үгүйсгэх эсвэл хязгаарлах хууль ёсны үндэслэл болж чадахгүй. Энэ загвар нь хөгжлийн бэрхшээл нь хүний олон талт нөхцөл байдал, өөрийн үнэлэмжийн нэг хэсэг гэдгийг харгалзан үзэхийг шаардана. Түүнчлэн хүний эрхүүд нь **салшгүй, харилцан уялдаа холбоотой**, хуваагдашгүй шинжтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. (Хүлээн зөвшөөрөх хэмжээс нь гутаан доромжлол, хэвшмэл ойлголт, хүчирхийлэлтэй тэмцэж, хүний эрхэм чанарыг хүндэтгэх, хүн бүрийн олон талт ба огтлолцсон ялгаварлан гадуурхалтыг (intersectionality) хүлээн зөвшөөрөх тухай юм)
10. Конвенцийн 3 дугаар зүйлд заасан нийтлэг зарчим нь тэгш байдлын албан ёсны загвараас нийгэм-эдийн засгийн бодит тэгш байдлыг хангах орчны ба үр дүнгийн тэгш байдлын загвар руу шилжихэд чухал хөгжлийн үе шат болж байна.
 - **Албан ёсны тэгш байдлын загвар** (formal equality) нь ижил нөхцөл байдалд буй хүмүүст ижил байдлаар хандаж шууд ялгаварлан гадуурхалтыг арилгахад чиглэдэг. Энэ нь сөрөг хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг бууруулахад тус дөхөмтэй боловч хүний хоорондын ялгааг харгалзан үздэггүй учраас ялгааны хоёрдмол байдлыг (dilemma of difference) шийдвэрлэх бодит арга зам болж чаддаггүй.
 - **Харин орчны ба үр дүнгийн тэгш байдлын загвар** нь шууд бус, бүтэц, тогтолцооны түвшний ялгаварлан гадуурхалтыг мөн хамарч, эрх мэдэл, нөлөөний тэнцвэргүй байдлыг тооцон үздэг. Энэ нь тэгш байдлыг хангахад хүний хоорондын ялгааг зарим үед тооцохгүй орхих ба хүлээн зөвшөөрөх хоёрын аль аль нь шаардлагатай байдгийг хүлээн зөвшөөрдөг.
11. **Хүн бүрийг хамруулсан тэгш байдал (Inclusive Equality)** гэдэг шинэ үзэл баримтлалыг Конвенцын хэрэгжилтийн явцад хөгжүүлсэн. Энэ нь бодит тэгш байдлыг гүнзгийрүүлэн дараах дөрвөн хэмжээсийг хамардаг:

- (a) **Дахин хуваарилалтын хэмжээс** – эдийн засаг, нийгмийн сул талыг шударгаар арилгах;
- (b) **Хүлээн зөвшөөрөх хэмжээс** – Хүлээн зөвшөөрөх хэмжээс нь гутаан доромжлол, хэвшмэл ойлголт, хүчирхийлэлтэй тэмцэж, хүний нэр төрийг хүндэтгэх, хүн бүрийн олон талт ба огтлолцсон ялгаварлан гадуурхалтын үзэгдлийн бодитой байгааг хүлээн зөвшөөрөх Огтлолцсон ялгаварлан гадуурхалтын үзэгдлийн бодитой байгааг хүлээн зөвшөөрөх (intersectionality)
- (c) **Оролцооны хэмжээс** – хүнийг нийгмийн бүрэн эрхт гишүүн болгон таниж, нийгмийн амьдралд бүрэн оролцуулах;
- (d) **Зохицуулалтын хэмжээс** – ялгаатай байдлыг хүний эрхэм чанарын нэг хэсэг хэмээн үзэж, түүнд зохицсон орон зай, боломжийг бий болгох. Конвенцын бүхэл бүтэн бүтэц нь нэгтгэсэн тэгш байдлын зарчимд тулгуурласан байдаг.

IV. ТЭГШ БАЙДАЛ БА ҮЛ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХЫН ЭРХ ЗҮЙН ШИНЖ



- 12. **Тэгш байдал болон үл ялгаварлан гадуурхах** нь хүний эрхийн салшгүй бүрэлдэхүүн төдийгүй **суурь зарчмууд** юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн 3 дугаар зүйлд тэдгээрийг суурь зарчим, харин 5 дугаар зүйлд **хууль ёсны эрх** хэмээн тодорхойлсон байдаг. Энэ хоёр ойлголт нь Конвенцод туссан бусад бүх зарчим болон эрхийг тайлбарлах үндэс суурь болдог. Тэгш байдал ба үл ялгаварлан гадуурхах нь Конвенцоор баталгаажуулсан олон улсын хамгаалалтын гол тулгуур бөгөөд тэдгээрийг хангах нь гишүүн улсуудын хувьд **шууд хэрэгжүүлэх ёстой нийлмэл хууль зүйн үүрэг** юм. Энэ нь зөвхөн аажмаар биелүүлэх зорилт (progressive realization)-ын хүрээнд үл хамаарна.
- 13. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйлтэй адилаар Конвенцийн 5 дугаар зүйл нь бусад зохицуулалтаас ангид, бие даасан эрхийг баталгаажуулсан байдаг. Энэ нь нийтийн эрх зүйн бүх байгууллагаас хэрэгжүүлэх бөгөөд бүх салбарт хууль зүйн хувьд ч, бодит байдал дээр ч (de jure болон de facto) ялгаварлан гадуурхалтыг хориглоно. Үүнээс гадна уг заалтыг Конвенцийн 4 дүгээр зүйлийн 1 (e) дэх хэсэгтэй уялдуулан хэрэглэвэл уг хориг нь хувийн салбарт ч мөн **өргөтгөн хэрэгжих** ёстой болох нь тодорхой болно.

V. НОРМАТИВ АГУУЛГА



A. Хуулийн өмнө эрх тэгш байх (5.1 дэх заалт)

14. Олон улсын зарим хүний эрхийн гэрээнүүдэд "хуулийн өмнө эрх тэгш байх" гэх нэр томъёо хэрэглэгддэг бөгөөд энэ нь хүний хувийн шинж, онцлогоос үл хамааран хуулийг хэрэглэх, хуулийн зохицуулалтад хамаарах бүх салбарт тэгш эрх эдлэхийг баталгаажуулдаг. Шударга ёсыг хэрэгжүүлэхийн тулд шүүх эрх мэдэл болон хууль сахиулах байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлах ёсгүй бөгөөд энэ тохиолдолд л энэхүү эрх бүрэн хангагдана.

Конвенцод хэрэглэсэн "хуульд адил тэгш захирагдах" гэх ойлголт нь онцлогтой. Энэ нь хүнийг хууль зүйн харилцаанд оролцох, хуульд захирагдах, түүнээс үр ашиг хүртэх боломжийг баталгаажуулдаг. Хуулийн өмнө эрх тэгш байх нь хуулиар хамгаалуулах эрхийг илэрхийлдэг бол хуульд адил тэгш захирагдах нь өөрийн эрх ашгийн төлөө хуулийг ашиглах боломжийг баталгаажуулдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүн бодитойгоор оролцож, эрхээ үр нөлөөтэй хамгаалуулах бүрэн эрхтэй.

Хуулийн өмнө эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрнө гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хязгаарлах, бууруулах, эсвэл үгүйсгэх аливаа хууль тогтоомжийг зөвшөөрөхгүй гэсэн үг бөгөөд бүх хууль, бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлийн асуудлыг тусгахыг шаардана.

15. Конвенцийн 4 дүгээр зүйлийн 1 (b), (c) дэх заалтуудтай уялдуулан авч үзвэл "хуулийн өмнө эрх тэгш байх" болон "хуульд адил тэгш захирагдах" ойлголтууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг үгүйсгэсэн хүчин төгөлдөр хууль, заншил, практикийг өөрчлөх буюу хүчингүй болгохыг шаарддаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дэмжих, хамгаалах бодлого, хөтөлбөрийг бүх шатанд тусгахыг нийтийн эрх зүйн байгууллагуудад үүрэг болгож байна.

B. Хуулиар хамгаалуулах, адил ашиг хүртэх (5.1 дэх заалт)

16. "Хуулийн өмнө эрх тэгш байх" болон "хуульд адил тэгш хамгаалуулах, адил ашиг хүртэх" нь харилцан уялдаатай ч ялгаатай ойлголтууд юм. Хуулийн өмнө эрх тэгш байх гэдэг нь олон улсын хүний эрхийн гэрээнд танигдсан суурь зарчим бөгөөд гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг ялгаварлан гадуурхсан хууль, бодлого батлахыг эсэргүүцэж, ийм зохицуулалтыг өөрчлөх үүрэгтэй.

Конвенцийн 5 дугаар зүйлийг 1, 3, 4 дүгээр зүйлүүдтэй хамт хэрэглэвэл, гишүүн улсууд хуульд заасан эрх тэгш байдлыг бодитоор хангахын тулд хүртээмж, тохирсон хэрэглэгдэхүүн, хувийн дэмжлэгийг тогтмол бүрдүүлэх шаардлагатай болох нь тодорхой харагдана.

"Хуулиар адил ашиг хүртэх" гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хуульд заасан хамгаалалт, ашиг тусыг бодитоор хүртэх боломжийг баталгаажуулахыг илэрхийлдэг. Энэ нь хууль, бодлогын хүртээмжийг хангах, саад бэрхшээлийг арилгах, шүүх болон хууль зүйн бүх үйлчилгээнд тэгш хүртээмжийг хангахыг гишүүн улсаас шаарддаг.

С. Ялгаварлан гадуурхахыг хориглох ба адил тэгш хууль зүйн хамгаалалт (5.2 дахь заалт)

17. Конвенцийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон түүнтэй холбоотой хүмүүсийн (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх зэрэг) **тэгш байдлын эрхийг хангах хууль зүйн шаардлагыг** тусгасан. Хөгжлийн бэрхшээлийн үндсэн дээрх аливаа ялгаварлан гадуурхалтыг хориглох үүрэг нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг төдийгүй тэдний холбоотой хүмүүсийг хамарна. Мөн гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ялгаварлан гадуурхлын бүх хэлбэрийн **эсрэг адил тэгш, үр нөлөөтэй хууль зүйн хамгаалалт** олгох эерэг үүргийг хүлээдэг.

Хөгжлийн бэрхшээлд суурилсан ялгаварлан гадуурхалтыг Конвенцийн 2 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

"Хөгжлийн бэрхшээлийн улмаас аливаа хүний улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон бусад салбарт бусдын адил тэгш үндсэн дээр бүх төрлийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлэх, хэрэгжүүлэх боломжийг үгүйсгэх, сулруулах зорилгоор буюу тийм үр дүнд хүргэдэг аливаа ялгаа, хасалт, эсвэл хязгаарлалтыг хэлнэ. Энэ нь бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг хамрах бөгөөд шаардлагатай тохируулгаас татгалзах үйлдлийг ч багтаана."

Энэхүү тодорхойлолт нь олон улсын хүний эрхийн гэрээнүүдийн ялгаварлан гадуурхалтын хууль зүйн тодорхойлолтод тулгуурласан. Жишээлбэл, **Арьс өнгөөр бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг устгах тухай олон улсын конвенцын** 1 дүгээр зүйл, **Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын** 1 дүгээр зүйлд ийм тодорхойлолт бий. Гэвч хөгжлийн бэрхшээлийн эрхийн тухай Конвенцын тодорхойлолт нь тэдгээрээс хоёр талаараа цааш өргөжсөн.

- Нэгдүгээрт, энэ тодорхойлолтод **"Шаардлагатай тохируулгаас татгалзах"-ыг ялгаварлан гадуурхалтын хэлбэр** болгон тусгасан.

- Хоёрдугаарт, **"бусадтай адил тэгш үндсэн дээр"** гэх хэллэгийг шинээр нэвтрүүлсэн.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 1, 3 дугаар зүйлд "эрэгтэй, эмэгтэй хүний тэгш байдлын үндсэн дээр" гэсэн арай хязгаарлагдмал хэллэг хэрэглэсэн байдаг бол хөгжлийн бэрхшээлийн эрхийн тухай Конвенцын "бусадтай адил тэгш үндсэн дээр" гэх заалт нь зөвхөн ялгаварлан гадуурхалтын тодорхойлолтод бус, бүхэл бүтэн Конвенцоор дамжин шингэсэн суурь зарчим юм.

Нэг талаас, энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийт хүн амын адил эрх, ашиг тусыг олгож, илүү ч үгүй дутуу ч үгүй адил тэгш байлгах ёстойг илэрхийлнэ. Нөгөө талаас, гишүүн улсуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бодит тэгш байдлыг хангах зорилгоор тодорхой, бодитой арга хэмжээ авахыг шаардаж байна. Ингэснээр тэд бүх хүний эрх, үндсэн эрх чөлөөг бусдын адил эдлэх боломжийг бодит амьдрал дээр хангах учиртай.

18. "Аливаа ялгаварлан гадуурхалтыг хориглох" үүрэг нь ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хамардаг. Олон улсын хүний эрхийн практикт дараах дөрвөн үндсэн хэлбэрийг тодорхойлсон бөгөөд эдгээр нь дангаар, эсхүл зэрэгцэн тохиолдож болно. Үүнд:

- (a) **Шууд ялгаварлан гадуурхалт.** Ижил нөхцөл байдалд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өөрийн хөгжлийн бэрхшээлтэй холбоотой шинжээр бусадтай харьцуулахад² илүү дордуулан харьцаж байгаа тохиолдолд шууд ялгаварлан гадуурхалт үүсдэг. Мөн харьцуулах ижил нөхцөл байхгүй үед хориглосон шинжид суурилсан сөрөг үйлдэл, эс үйлдэхүй гаргасан бол энэ нь шууд ялгаварлан гадуурхалтад тооцогдоно. Ялгаварлагч талын санаа зорилго, сэдэл нь тухайн үйлдэл ялгаварлан гадуурхалт мөн эсэхийг тогтооход хамааралгүй. Жишээлбэл, улсын сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургалтын хөтөлбөрөө өөрчлөхөөс зайлсхийхийн тулд элсүүлэхээс татгалзвал энэ нь хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалсан **шууд ялгаварлан гадуурхалт** болно.

- (b) **Шууд бус ялгаварлан гадуурхалт.**³ Хууль, бодлого эсвэл практик нь ил харахад төвийг сахисан мэт боловч хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хэтэрхий сөрөг үр нөлөөтэй байвал шууд бус ялгаварлан гадуурхалт болно.

Энэ нь боломж олгож байгаа мэт харагдсан ч тухайн хүний байдал, нөхцөлөөс шалтгаалан түүнийг бодитоор ашиглах боломжгүй байх тохиолдлыг хэлнэ. Жишээ нь, сургууль оюуны хөгжлийн бэрхшээлтэй

² Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хорооны 20 дугаар Ерөнхий тайлбар (2009)

³ "Эдийн засаг, нийгэм соёлын эрхэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай", 10 дугаар хэсгийг үзэх сурвалж мөн адил

хүүхдийг суралцахыг зөвшөөрсөн ч сурах бичгийг "амархан уншигдах" форматаар бэлтгэхгүй бол хүүхэд бодитоор хичээлд хамрагдах боломжгүй тул энэ нь шууд бус ялгаварлан гадуурхалт болно. Мөн хөдөлгөөний хязгаарлалттай ажил горилогчийн ярилцлагыг лифтгүй барилгын хоёрдугаар давхарт зохион байгуулавал, түүнийг ярилцлагад оруулахыг зөвшөөрсөн ч бодит байдал дээр **тэгш бус байдал** үүснэ.

- (c) **Шаардлагатай тохируулгаас татгалзах.** Конвенцийн 2 дугаар зүйлд зааснаар хүний эрх, эрх чөлөөг бусдын адил эдлэхэд шаардлагатай боловч хэт их буюу үндэслэлгүй дарамт учруулахгүй өөрчлөлт, зохицуулалтыг хийхээс татгалзвал энэ нь ялгаварлан гадуурхалтын хэлбэр болно. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамтрагчтай нь нэвтрүүлэхээс татгалзах, эсвэл тохирсон орон зай, хэрэглэгдэхүүн олгохоос татгалзах нь **шаардлагатай тохируулгаас татгалзсан** тохиолдол юм.
- (d) **Дарамт шахалт.** Хөгжлийн бэрхшээлтэй эсвэл бусад хориглосон шинжтэй холбоотой хүсээгүй үйлдэл, үйл ажиллагаа нь тухайн хүний эрхэм чанарыг доромжилж, сүрдмэл, дайсагнасан, дорд үзсэн, ичгүүртэй, эсвэл доромж орчин бий болгосон тохиолдолд энэ нь ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр болно. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дорд үзэх, ялгаварлан гадуурхах үг, үйлдлээр илэрч болно. Ялангуяа тусгаарласан орчин (жишээлбэл; асрамжийн байр, тусгай сургууль, сэтгэцийн эмнэлэг)- д амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд ийм хэлбэрийн ялгаварлалт түгээмэл тохиолддог бөгөөд ихэнхдээ ил тод бус, шийтгэлгүй өнгөрөх эрсдэлтэй байдаг.

"Дээрэлхэлт" болон түүний **цахим хэлбэр болох цахим дээрэлхэлт, цахим үзэн ядалт** нь үзэн ядалтад суурилсан гэмт хэргийн хамгийн ноцтой, хүчирхийлэлтэй хэлбэрүүдийн нэг юм. Мөн хөгжлийн бэрхшээлд суурилсан хүчирхийлэл бүх хэлбэрээрээ (жишээлбэл, хүчин, хүчирхийлэл, мөлжлөг, үзэн ядалтад суурилсан гэмт хэрэг, зодоон) ялгаварлан гадуурхалтын илрэл болно.

19. Ялгаварлан гадуурхалт нь нэг шинжид (жишээлбэл, хөгжлийн бэрхшээл эсвэл жендэр) суурилж болохоос гадна олон шинжийн давхцал болон огтлолцолд суурилж илэрч болно. **Огтлолцсон ялгаварлан гадуурхалт** (intersectional discrimination) нь хөгжлийн бэрхшээлтэй хүн буюу түүнтэй холбоотой хүн хөгжлийн бэрхшээлээс гадна арьс өнгө, хүйс, хэл, шашин, үндэс угсаа, жендэр зэрэг бусад шинжийн нөлөөгөөр **нэгэн зэрэг ялгаварлан гадуурхалт** тулгарч буй нөхцөл байдлыг хэлнэ. Огтлолцсон ялгаварлан гадуурхалт нь шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалт, шаардлагатай тохируулгаас татгалзах, эсвэл дарамт шахалтын хэлбэрээр илэрч болно.

Жишээлбэл: эрүүл мэндийн ерөнхий мэдээллийг хүртээмжгүй форматаар хүргэх нь бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нөлөөлдөг бол, хараагүй эмэгтэйд гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээг олгохоос татгалзах нь түүний эрхийг жендэр ба хөгжлийн бэрхшээл гэсэн огтлолцсон шинжээр хязгаарлаж буй хэрэг юм. Ийм тохиолдолд ялгаварлан гадуурхалтын үндэслэлийг тусад нь ялгаж салгахад хүндрэлтэй байдаг.

Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг олон давхар болон огтлолцсон ялгаварлан гадуурхалтыг шийдвэрлэх ёстой. Хорооноос тодорхойлсноор:

- **Олон давхар ялгаварлан гадуурхалт (multiple discrimination)** гэдэг нь нэг хүн хоёр буюу түүнээс олон шинжээр давхар ялгаварлагдаж, түүний нөхцөл байдал улам хүндрэхийг хэлнэ.
- **Огтлолцсон ялгаварлан гадуурхалт (intersectional discrimination)** гэдэг нь хэд хэдэн шинж нэгэн зэрэг, харилцан үйлчилж, ялгаж салгах боломжгүйгээр нөлөөлснөөр тухайн хүнийг өвөрмөц сул тал, ялгаварлалд өртүүлэхийг хэлнэ.⁴

20. "Хөгжлийн бэрхшээлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт" нь зөвхөн одоо хөгжлийн бэрхшээлтэй байгаа хүнийг бус, өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй байсан, ирээдүйд хөгжлийн бэрхшээлтэй болох магадлалтай, хөгжлийн гэж тооцогддог, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүнд холбоотой, дэмжлэг үзүүлдэг хүнийг ч хамарна. Энэ сүүлийнхийг **"холбоогоор ялгаварлан гадуурхалт (discrimination by association)"** гэж нэрлэдэг.

Ийнхүү Конвенцийн 5 дугаар зүйлийг өргөн хүрээнд хэрэглэх болсон нь хөгжлийн бэрхшээлтэй холбоотой бүх төрлийн ялгаварлан гадуурхлын нөхцөл, үйлдлийг устгаж, тэдгээртэй тэмцэх зорилготой.

21. "Аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхахаас хамгаалах" гэдэг нь ялгаварлан гадуурхалтын бүх боломжит үндэслэл болон тэдгээрийн огтлолцлыг тооцохыг шаарддаг. Боломжит үндэслэлд дараах зүйлс хамаарна: хөгжлийн бэрхшээл; эрүүл мэндийн байдал; удамшлын буюу бусад өвчний эрсдэл; арьс өнгө; угсаа гарал; хүйс; жирэмслэлт ба эх/эцэг болох байдал; иргэний байдал; гэр бүлийн болон мэргэжлийн байдал; жендэрийн илэрхийлэл; хэл; шашин шүтлэг; улс төрийн болон бусад үзэл бодол; үндэстэн, угсаатан, уугуул эсвэл нийгмийн гарал; цагаач, дүрвэгч эсвэл орогнол хүсэгчийн байдал; үндэстний цөөнхөд харьяалагдах байдал; эдийн засгийн болон өмчийн байдал; төрсөн нөхцөл; нас; эсвэл эдгээрийн аль нэгийн хослол, мөн түүнтэй холбоотой бусад шинж.

⁴ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны 3 дугаар Ерөнхий тайлбар (2016) - "Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ба охидын эрхийн тухай", 4 (с) ба 16 дугаар хэсгийг үз.

22. "Ялгаварлан гадуурхлын эсрэг тэгш бөгөөд үр нөлөөтэй хууль зүйн хамгаалалт" гэдэг нь гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахаас хамгаалах эерэг үүрэгтэй гэсэн үг юм. Энэ нь **нарийвчилсан, иж бүрэн ялгаварлан гадуурхлын эсрэг хууль тогтоомж** батлах, хөгжлийн бэрхшээлд суурилсан болон бусад хэлбэрийн ялгаварлан гадуурхлыг хуульд ил тод хориглох, холбогдох хууль зүйн үр нөлөөтэй арга хэмжээ, шийтгэл, нөхөн төлбөрийн механизмыг бий болгохыг хамарна.

Ялангуяа огтлолцсон ялгаварлан гадуурхлын тохиолдолд иргэний, захиргааны болон эрүүгийн процессоор үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтыг хангах ёстой. Харин ялгаварлан гадуурхалт тогтолцооны шинжтэй бол зөвхөн хувь хүнд нөхөн төлбөр олгох нь бодит өөрчлөлт авчрахгүй.

Ийм нөхцөлд гишүүн улсууд **ирээдүйд чиглэсэн, эдийн бус нөхөн төлбөрийн арга хэмжээг** хууль тогтоомждоо тусгаж, хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ нь хувийн байгууллага, аж ахуйн нэгжийн зүгээс үйлдэгдэж буй ялгаварлан гадуурхлын эсрэг цаашид илүү үр нөлөөтэй хамгаалалтыг бий болгох боломжийг бүрдүүлнэ.

D. Конвенцийн 5 (3) дугаар заалт: Шаардлагатай тохируулга

23. Шаардлагатай тохируулга нь хөгжлийн бэрхшээлийн нөхцөлд **ялгаварлан гадуурхахгүй байх шууд хэрэгжих үүргийн салшгүй хэсэг**⁵ юм. Жишээлбэл: барилга, байгууламж, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох; тоног төхөөрөмжийг өөрчлөх; үйл ажиллагааг дахин зохион байгуулах; ажлын цагийг өөрчлөн тохируулах; сургалтын хөтөлбөр, сурах материал, сургалтын аргыг өөрчлөх; эмнэлгийн үйлчилгээг тохируулах; эсвэл дэмжлэг үзүүлэх ажилтанд хандах боломжийг хэт их буюу үндэслэлгүй дарамтгүйгээр бүрдүүлэх зэрэг орно.
24. Шаардлагатай тохируулгын үүрэг нь хүртээмжийг хангах үүргээс ялгаатай. Аль аль нь хүртээмжийг хангах зорилготой боловч:
- **Хүртээмжийн үүрэг (accessibility)** нь **ex ante** шинжтэй буюу урьдчилан, системийн хэмжээнд бүгдэд зориулагдан хэрэгждэг. Жишээлбэл, барилга, үйлчилгээ, бүтээгдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусадтай адил тэгшээр хандах боломжийг хангах. Энэ үүрэг нь урьдчилан сэргийлэх, системийн шинжтэй үүрэг бөгөөд Конвенцийн 4 (3) дугаар зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай зөвлөлдөж стандарт тогтоох шаардлагатай.

⁵ Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хорооны 5 дугаар Ерөнхий тайлбар (1994) "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай", 15 дугаар хэсгийг үз.

- **Шаардлагатай тохируулга (reasonable accommodation)** нь **ex nunc** шинжтэй буюу тодорхой хүн хэрэгцээ илэрхийлсэн мөчөөс эхлэн шууд хэрэгжих үүрэг юм. Энэ нь ихэвчлэн тухайн хүн эсвэл түүний төлөөлөгчөөс хүсэлт гаргасны үндсэн дээр явагддаг боловч заавал тэгж байх албагүй. Хуулийн этгээд тухайн хүний хэрэгцээг мэдсэн эсвэл мэдэх боломжтой нөхцөлд ч үүрэг үйлчилнэ. Зарим тохиолдолд шаардлагатай тохируулга нь нийтлэг буюу олон нийтийн ашиг хүртээмж болж хувирдаг; өөр тохиолдолд зөвхөн хүсэлт гаргасан хүн, бүлэгт үйлчилнэ. Энэ нь **хувь хүний хэрэгцээнд чиглэсэн, шууд хариу үйлдэл үзүүлэх үүрэг** бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй шууд харилцан ярилцах замаар шийдэгдэнэ.
25. Конвенцийн 2 ба 5 дугаар зүйлд заасны дагуу шаардлагатай тохируулгын үүрэг нь хоёр хэсгээс бүрдэнэ.
1. Шаардлагатай тохиолдолд тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхээ эдлэх, хэрэгжүүлэх боломжтой байлгахын тулд тохируулга **хийх эерэг хууль үүрэг**.
 2. Энэхүү тохируулга нь тухайн этгээдэд **хэт их буюу үндэслэлгүй дарамт** учруулахгүй байх шаардлага.
- **"Шаардлагатай тохируулга"** гэдэг бол нэг бүхэл ойлголт бөгөөд "шаардлагатай" гэдгийг тусгай хязгаарлалт мэт ойлгож болохгүй. Энэ нь зардал, нөөцийн хүрэлцээг урьдчилан шалгах шалгуур биш, харин тухайн тохируулга хөгжлийн бэрхшээлтэй хүнд бодитоор ач холбогдолтой, тохиромжтой, үр нөлөөтэй эсэхийг илэрхийлдэг.
 - **"Хэт их буюу үндэслэлгүй дарамт"** гэдэг ойлголт нь тухайн тохируулгын боломжийн хязгаарыг тогтооно. Энэ хоёр нэр томъёог ижил утгаар ойлгож болно.
 - Шаардлагатай тохируулгыг **"тусгай арга хэмжээ"**-тэй андуурч болохгүй. Аль аль нь бодит тэгш байдлыг хангахад чиглэдэг боловч шаардлагатай тохируулга нь ялгаварлан гадуурхахгүй байх үүрэг, харин тусгай арга хэмжээ нь түүхэн болон тогтолцооны ялгаварлалтыг арилгах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүнд бусдаас давуу боломж олгох явдал юм. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувийн хэвшил дэх ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх түр хугацааны арга хэмжээ, эсвэл их дээд сургуульд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын тоог өсгөх дэмжлэгийн хөтөлбөр.
 - Мөн шаардлагатай тохируулгыг **"дэмжлэгийн үйлчилгээ"**-тэй андуурч болохгүй. Жишээлбэл, бие даан амьдрах эрхийн хүрээнд хувийн туслах ажилтан, эсвэл эрх зүйн чадавх хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг бол өөр агуулга юм.

- **Шүүхэд хүртээмжтэй байдлыг бий болгох "процессын тохируулгыг"** ч мөн шаардлагатай тохируулгатай андуурч болохгүй. Процессын тохируулга нь пропорциональ байдлын шалгуураар хязгаарлагддаггүй.

26. Шаардлагатай тохируулгыг хэрэгжүүлэх гол чиглэлүүд нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүний эрхийг эдлэхэд саад болж буй бэрхшээлийг тухайн хүнтэй хамтран тодорхойлох, арилгах;
- Тохируулга нь хууль зүйн болон бодит хувьд боломжтой эсэхийг үнэлэх (хууль ёсоор эсвэл материалын хувьд боломжгүй бол тохируулга хэрэгжих боломжгүй);
- Тохируулга нь тухайн эрхийг эдлэхэд **шаардлагатай, тохиромжтой, үр нөлөөтэй** эсэхийг үнэлэх;
- Тохируулга нь хэт их буюу үндэслэлгүй дарамт үүсгэж байгаа эсэхийг үнэлэх; үүнийг тогтооход хэрэглэсэн арга хэрэгсэл болон зорилгын хоорондын пропорциональ харьцааг тооцох;
- Тохируулга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлыг дэмжих, ялгаварлан гадуурхалтыг арилгах үндсэн зорилгод хүрч байгаа эсэхийг хангах; тохиолдол тус бүрийг тухайн хүнтэй болон холбогдох байгууллагатай зөвшилцөн авч үзэх; үнэлэх хүчин зүйлсэд зардал, ашиглах боломжтой нөөц (нийтийн татаас орно), тухайн байгууллагын хэмжээ, өөрчлөлтийн нөлөө, гуравдагч талын ашиг, бусдад үзүүлэх сөрөг нөлөө, эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлага орно. Нийтийн болон хувийн байгууллагын хувьд бүхэл бүтэн байгууллагын нөөцөөр тооцно, зөвхөн нэг нэгжийн хүрээгээр хязгаарлахгүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд тохируулгын зардлыг өөрсдөд нь үүрүүлэхгүй байх;
- "Хэт их буюу үндэслэлгүй дарамт" гэж маргаж буй этгээдэд нотлох үүргийг оногдуулах.

27. Шаардлагатай тохируулгаас татгалзсан тохиолдолд тухайн шийдвэрийг зөвхөн **объектив шалгуурт тулгуурлан**, цаг тухайд нь үндэслэлтэй тайлбарлан мэдээлэх ёстой. Шаардлагатай тохируулгын үндэслэл нь тухайн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эрхээ эдлэгч ба үүрэг хүлээгчийн хоорондын харилцааны хугацаа, нөхцөл байдлаас хамаарч дүгнэгдэнэ.

Е. Конвенцийн 5 (4) дугаар заалт: Тусгай арга хэмжээ

28. **Эерэг тусгай арга хэмжээг** (affirmative action measures) хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлыг бодитоор хангах зорилгоор хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь түр хугацаанд хэрэгжүүлэх тусгай арга хэмжээ эсвэл позитив арга хэмжээнээс ялгаатай юм. Ийм арга хэмжээг олон улсын хүний эрхийн бусад гэрээнд, тухайлбал Эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн ялгаварлалтыг устгах тухай конвенцийн 4 дүгээр зүйл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тус тус заасан байдаг. Эдгээр арга хэмжээ нь төлөөлөл багатай эсвэл нийгмийн эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалж, тодорхой давуу байдал олгох зорилготой байдаг. Ихэвчлэн түр хугацаанд хэрэгждэг боловч тухайн нөхцөл байдал, хөгжлийн бэрхшээлийн онцлог, нийгмийн бүтцийн саад бэрхшээл зэргээс шалтгаалан зарим тохиолдолд байнгын арга хэмжээ шаардлагатай байж болно.

Тусгай арга хэмжээний жишээнд хамруулахад хүрч очих болон дэмжих хөтөлбөр, нөөцийг хуваарилах болон дахин хуваарилах, зорилтот элсэлт, ажилд авах болон албан тушаал дэвшүүлэх бодлого, квотын тогтолцоо, чадавхийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, мөн асаргаа сувилгааны үйлчилгээ, технологийн тусламжийн хэрэгсэл зэрэг орно.

29. Гишүүн улсуудын Конвенцийн 5 (4) дүгээр заалтын дагуу хэрэгжүүлсэн тусгай арга хэмжээ нь Конвенцын бүх зарчим болон заалтуудтай нийцсэн байх ёстой. Ялангуяа, эдгээр арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлах, сегрегацлах, хэвшмэл ойлголт бий болгох, гутаан доромжлох эсвэл өөр ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхах үр дагаварт хүрч болохгүй.

Иймд гишүүн улсууд тусгай арга хэмжээ хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийн байгууллагуудтай идэвхтэй зөвлөлдөж, хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай.

VI. ТЭГШ БАЙДАЛ БА ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГҮЙ БАЙХТАЙ ХОЛБОГДУУЛАН ГИШҮҮН УЛСЫН ЕРӨНХИЙ ҮҮРЭГ



30. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байх эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Энэ хүрээнд гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлах аливаа үйл ажиллагаанаас татгалзах ёстой. Ялангуяа, ийм ялгаварлал үүсгэдэг хууль, журам, заншил, практикийг өөрчлөх буюу хүчингүй болгох шаардлагатай.⁶ Хорооны жишээнүүдэд:

- эрх зүйн чадамжид халдаж буй асран хамгааллын хууль тогтоомж болон бусад дүрэм;
- хүчээр тусгаарлан байрлуулах, хүчээр эмчлэхийг зөвшөөрдөг сэтгэцийн эрүүл мэндийн хууль;⁷
- хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй, охидын зөвшөөрөлгүй үргүйдүүлэх (sterilization);⁸
- хүртээмжгүй орон сууц, институцийн бодлого;⁹
- тусгаарласан боловсролын тухай хууль, бодлого;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонгуулийн эрхээс нь хасдаг сонгуулийн хууль зэргийг багтаана.¹⁰

31. Тэгш эрх, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг бодитоор эдлэхийн тулд гишүүн улсууд дараах хэрэгжилтийн арга хэмжээг авах ёстой. Үүнд:

- (a) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, ялгаварлан гадуурхалтын утга учир, эрх зүйн хамгааллын боломжийн талаар хүн бүрийн мэдлэгийг дээшлүүлэх;
- (b) Конвенцийн эрхийг дотоодын шүүхээр хэрэгжүүлэх боломжтой болгож, ялгаварлан гадуурхалтад өртсөн бүх хүнд шударга шүүхэд нэвтрэх боломж олгох;
- (c) Ялгаварлан гадуурхалтын талаар гомдол гаргасан эсвэл тэгш байдлын заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажиллагаанд оролцсоны улмаас өшөө авалт, сөрөг хандлага, сөрөг үр дагавраас хамгаалах;

⁶ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны 1 дүгээр Ерөнхий тайлбар (2014) “Хуулийн өмнө тэгш хүлээн зөвшөөрөгдөх тухай”-г үз.

⁷ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо, 14 дүгээр зүйлийн талаарх удирдамж, 6 ба 14 дүгээр хэсгийг үз. Хорооны вэб хуудсаас авах боломжтой (www.ohchr.org/EN/HRBodies/CRPD/Pages/CRPDIndex.aspx).

⁸ Ерөнхий тайлбар № 5 (2017) — “Бие даан амьдрах болон нийгэмд хамрагдах эрхийн тухай”, 46 дугаар хэсгийг үз.

⁹ Ерөнхий тайлбар № 4 (2016) — “Хамруулах боловсролын эрхийн тухай”, 24 дүгээр хэсгийг үз.

¹⁰ Vujdosó болон бусад нь Унгарын эсрэг нэхэмжлэл (CRPD/C/10/D/4/2011)-ийг үз.

- (d) Хүн өөрөө болон түүнтэй холбоотой холбоод, байгууллага, хуулийн этгээдээр дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулах;
 - (e) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадамжийн талаарх хэвшмэл ойлголт ялгаварлан гадуурхлын хохирогчийг нөхөн олговор авах боломжгүй болгохоос сэргийлэхийн тулд нотолгоо, баримтын тусгай журам тогтоох;
 - (f) Тэгш байдлын эрхийг зөрчсөнд оногдуулах үр нөлөөтэй, зохистой, сөрөг үр дагавар үүсгэхүйц шийтгэл болон зохих нөхөн олговрыг хангах;
 - (g) Ялгаварлан гадуурхалтын маргаанд оролцогч нэхэмжлэгчдэд шударга шүүхэд нэвтрэх боломжоор хангахуйц хүрэлцээтэй, хүртээмжтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх.
32. Гишүүн улсууд ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэл өндөртэй тодорхой буюу дэд бүлгүүдийг (ялангуяа огтлолцсон ялгаварлан гадуурхалтад өртөгсөд) тодорхойлох ёстой. Тэдгээр бүлгийн бодит тэгш байдлыг түргэтгэх эсвэл хангахын тулд гишүүн улсууд тусгай арга хэмжээ авах үүрэгтэй.
33. Гишүүн улсуудын зөвлөлдөх үүргийн тухайд, Конвенцийн 4 (3), 33 (3) дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын Конвенцийн хэрэгжилт, хяналтад гүйцэтгэх чухал үүргийг онцолсон байдаг. Иймд гишүүн улсууд эдгээр байгууллагуудтай ойр, идэвхтэй хамтран ажиллах ёстой. Тэдгээр байгууллагууд нь нийгмийн өргөн олон талт байдлыг төлөөлөх учиртай бөгөөд тэдгээрт: хүүхэд, аутизмтай хүмүүс, генетикийн эсвэл мэдрэлийн өвчтэй хүмүүс, ховор болон архаг өвчтэй хүмүүс, альбинизмтай хүмүүс, ЛГБТИК хүмүүс, уугуул иргэд, хөдөө орон нутгийн иргэд, өндөр настнууд, эмэгтэйчүүд, зэвсэгт мөргөлдөөнд өртөгсөд, цөөнхийн болон цагаач гаралтай хүмүүс багтана. Ийм тохиолдолд л бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, тэр дундаа олон давхар, огтлолцсон ялгаварлан гадуурхалтын эсрэг бодит ахиц гарна.
34. Конвенцийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүн улсууд мэдээлэл цуглуулах үүрэгтэй. Тэд ялгаварлан гадуурхал, тэгш бус байдлын хэв маяг, хохирлын шалтгааныг илрүүлэхийн тулд зохих мэдээлэл, судалгааны өгөгдлийг цуглуулж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дүн шинжилгээ хийх ёстой. Хорооны ажигласнаар олон гишүүн улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтын шинэчилсэн өгөгдөл хангалтгүй байдаг. Ихэнх тохиолдолд хууль тогтоомж нь хөгжлийн бэрхшээл, хүйс, нас, жендэрийн баримжаа, үндэс угсаа, шашин, бусад шинжээр ялган бүртгэхийг зөвшөөрдөггүй. Гэвч ийм өгөгдөл, дүн шинжилгээ нь ялгаварлан гадуурхалтыг

арилгах, тэгш байдлыг хангах бодлогын үр нөлөөтэй арга хэмжээ боловсруулахад зайлшгүй чухал.

